# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
# ТУШААЛ

2019 оны 08 сарын 30 өдөр Дугаар А/402 Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дах заалт, Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар хооронд 2017 оны 6 дугаар сард байгуулсан "Монгол Улсын Зүрх судасны үндэсний төв ба зүрх судасны тусламж үйлчилгээг уялдуулан сайжруулах МОН/006" төслийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

081522

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 12 сарын 30-ны өдрийн
А/402 дугаар тушаалын хавсралт

## МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| № | Овог нэр | Харьяалал | Монгол Улсад ажиллах байгууллага | Хамтран ажиллах гадаадын байгууллага | Гэрчилгээний сери/дугаар | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл | Зөвшөөрлийн төрөл | Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Шарпентиер Арнауд Францойз Паскал<br><br>Sharpentier Arnaud Francois Pascal | Люксембургийн Их Гүнт Улс | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар | ГЭ0002448 | Цээжний ба зүрхний мэс засал судлал | Эмчлэх | 2019.09.14-2019.09.22 /9 хоног/ |
| 2. | Биллауд Филиппе Жэйн Ричард<br><br>Billaud Philippe Jean Richard | Бүгд Найрамдах Франц Улс | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар | ГЭ0002449 | Цээжний ба зүрхний мэс засал судлал | Эмчлэх | 2019.09.14-2019.09.22 /9 хоног/ |